



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/108

Шивээговь сум

Мал, амьтны отор нүүдэл, шилжилт  
хөдөлгөөнийг зохицуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.3, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол "Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтанд авах журам"-ын 2.6, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал, амьтны гоц халдварт өвчний эрсдэл бүхий Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Дундговь аймгуудаас отор, нүүдэл, гарал үүслийн бичиггүй мал амьтан хүлээн авахыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Мал, амьтны гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор технологийн дагуу түргэн шуурхай хийж гүйцэтгэхэд онцгой анхаарч, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, мал эмнэлгийн нэгжийн эмчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Ш.Буяннэмэх)-д үүрэг болгосугай.

3. Дээрх аймгуудаас мал, амьтны шилжилт хөдөлгөөн хийлгэхгүй, отор нүүдлээр дамжин өнгөрүүлэхгүй байх, хяналт шалгалтыг сайжруулахыг Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр), 2 дугаар багийн Засаг дарга (С.Отгонбаатар) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ